



САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Баянцагаан сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: БНА-2019/138/СТА-ТШЗ

Баянхонгор хот. 2019 он

Тэргүүлэх аудитор: Б.Мөнхбат

Утас: 7044-2584

Цахим хаяг: munkhbatb@audit.gov.mn

Аудитын менежер: Д.Цэцэгмаа

Утас: 7044-2424

Цахим хаяг: tsetsegmaad@audit.gov.mn

Ахлах аудитор: Б.Должмаа

Утас: 88119345

Цахим хаяг: doljmaab@audit.gov.mn

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт
АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
АОУС	Аудитын олон улсын стандарт

Баянцагаан сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

АГУУЛГА

1	Аудитын гэрчилгээ.....	3
2	Аудитын тайлан	5
2.1	Оршил	5
2.2	Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага.....	5
2.3	Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт	6
2.4	Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин.....	6
2.5	Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ	7
2.6	Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал	7
2.7	Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар.....	8
2.8	Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн.....	8
2.9	Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал.....	9
2.10	Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга	9
2.11	Шилэн дансны мэдээлэл.....	9
2.12	Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга	10
2.13	Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл.....	10
3	Менежментийн захидал	11
4	Аудитлагдсан санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	13

1 Аудитын гэрчилгээ



**БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

64101 Номгон, Баянхонгор сум
Утас, факс 70-44-25-84
E-mail: bayankhongor@audit.gov.mn

2019.01.31 № 2/05

танай _____-ны № _____ т

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-т заасны дагуу Баянцагаан сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

Зөрчилгүй санал дүгнэлт

Баянцагаан сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Баянцагаан сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2018 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох

2518472

бүртгэлийн бодлого, бүртгэлийн хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

Үүрэг хариуцлага

Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-т заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудитын хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Б.МӨНХБАТ

2 АУДИТЫН ТАЙЛАН

2.1 Оршил

Баянцагаан сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг сургуулийн захирал С.Нандинцэцэгт танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчлийн талаарх тайлбар, тодруулга зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй болгох зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

Дараагийн заалтад аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг батлагдсан ангилал, үзүүлэлтээр бэлтгэж оруулав.

2.2 Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 15.2, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Баянцагаан сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Баянцагаан сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2019.01.26-наас 2019.01.29-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2019.01.31-ны өдөр эцэслэн баталгаажуулж, төсвийн захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Баянхонгор аймаг дахь төрийн аудитын газрын ахлах аудитор Б. Должмаа хариуцаж хэрэгжүүлэв.

Баянцагаан сумын Ерөнхий боловсролын сургууль 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Баянхонгор аймаг дахь төрийн аудитын газарт 2019.01.25-ны өдөр ирүүлсэн байна.

2.3 Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

Аудитын явцад АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан төрийн аудитын байгууллагын санхүүгийн тайлангийн аудитын талаарх бодлого, арга зүйг мөрдөж ажиллав.

Дээрх стандарт, зарчимд нийцүүлж Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, түүнд тусгасан үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

Аудитын үйл явц, үр дүнг АДБОУС, АОУС-ын дагуу шат шатны чанарын хяналт хийж баталгаажуулсан болно.

Аудитыг дээрх бодлого, арга зүйд нийцүүлэн төлөвлөлтийн шатанд баталсан аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Аудит хийхэд Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, Төсвийн тухай хууль болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг гол шалгуур болголоо.

2.4 Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Бид аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу байгууллагын үйл ажиллагаа, түүний гадаад дотоод орчны талаар шаардлагатай хэмжээнд судалж, тэдгээрийн үр дүнг аудитад ашигласан.

Баянцагаан сумын Ерөнхий боловсролын сургуулийн талаарх ерөнхий мэдээллийг аудитыг төлөвлөх үе шатанд шинэчлэн баримтжуулж, А101 маягтаар баталгаажуулсан болно.

Эрхэм зорилго:

Баянцагаан сумын Ерөнхий боловсролын сургууль нь “Өөртөө итгэлтэй бусдыг хүндэтгэдэг оюунлаг эрүүл зөв хүн төлөвшүүлэх” гэсэн эрхэм зорилгын дор үйл ажиллагааны чиглэл зорилгоо тодорхойлон ажиллажээ.

Үйл ажиллагааны чиглэл:

Баянцагаан сумын Ерөнхий боловсролын сургууль үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Бага, суурь, бүрэн дунд боловсролын цөм хөтөлбөрийг хэрэгжүүлэх
- Үндэсний болон аймгийн хөгжлийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх
- Сурагчдыг дугуйлан, сургалтад хамруулах
- Насан туршийн боловсрол олгох

Баянцагаан сумын Ерөнхий боловсролын сургуулийн үндсэн болон үндсэн бус үйл ажиллагааны талаар төлөвлөлтийн шатанд судалж, баримтжуулсан.

Баянцагаан сумын Ерөнхий боловсролын сургуулийн удирдлага төсвийн шууд захирагчийн хувьд дараах хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын Нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын хүрээнд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэж байна. Үүнд:

- Төсвийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Шилэн дансны тухай хууль
- Боловсролын тухай хууль

Тайлант хугацаанд дээрх бодлого, журамд томоохон шинэчлэлт, өөрчлөлт гарсан эсэх талаар дараах заалтад тэмдэглэв.

Байхгүй.

2.5 Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалах ёстой гол бодлого, хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Тус газрын одоо мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг Сангийн яамнаас авч хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын шинэчлэлт, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцтэй байгаа эсэхийг судалж үзэхэд шинээр батлагдсан бодлого, журамд нийцсэн байна.

Баянцагаан сумын Ерөнхий боловсролын сургуулийн санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа мэдээллийн технологи, бүртгэл мэдээллийн системийн үйл ажиллагаатай танилцан түүний нарийн төвөгтэй байдлыг үнэлэхэд 45 оноо авсан ба мэдээллийн технологийн мэргэжилтнийг аудитад татан оролцуулах шаардлагагүй гэж үзлээ.

Баянцагаан сумын Ерөнхий боловсролын сургууль санхүүгийн тайланг бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн "Санхүүгийн тооцоолох групп" ХХК-ийн Acolous 3 программ хангамж ашигладаг байна.

Баянцагаан сумын Ерөнхий боловсролын сургууль дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд Дунд гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт Бага гэж үзлээ.

2.6 Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитын явцад Баянцагаан сумын Ерөнхий боловсролын сургуулийн бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад

дотоод орчин, дотоод хяналтыг судалж, санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлантай холбоотой эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэлсэн.

Аудитыг төлөвлөх үе шатанд эрсдэлийн үнэлгээний урьдчилсан горим хэрэгжүүлэн 8 эрсдэлтэй асуудал тодорхойлж, эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн 8 асуудалд нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

Аудитын чиглэл тус бүрд хамаарах илрүүлсэн эрсдэлийн жагсаалт, түүний үнэлгээг Б301 маягтаар, эрсдэлтэй асуудлыг сорих аудитын горим, сорил, түүнийг баримтжуулах, нотлох зүйлс цуглуулах арга зүйг Б401, Б402 маягтаар тус тус баримтжуулав.

2.7 Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр үр дүнгийн зардлын 2 хувиар сонгов.

Баянцагаан сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2018 оны үр дүнгийн тайлангийн нийт зардал 963030,3 мянган төгрөг бөгөөд түүний 2 хувь болох 19,260.6 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Гүйцэтгэлийн шатанд шинж чанарын болон орчин нөхцлийн хувьд материаллаг байдал илрээгүй.

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлын түвшинг Б201, аудитыг гүйцэтгэх үе шатны материаллаг байдлын түвшинг В401 маягтаар тус тус баримтжуулан баталгаажуулав.

2.8 Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон эрсдэл тус бүрд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн горим сорилын хэрэгжилт, гол үр дүнгийн талаар дор нэгтгэн тэмдэглэв.

Эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн аудитын 5 чиглэлээр аудитын 8 горим сорил гүйцэтгэж, үнэлэхэд 2 асуудлыг алдаа, зөрчилтөйд тооцож, 6 асуудлыг алдаа, зөрчилд тооцохгүй гэж шийдвэрлэсэн бөгөөд аудитын явцад санхүүгийн тайланд залруулга хийгээгүй болно.

Аудитын явцад хийсэн залруулгын талаарх мэдээллийг В30103 маягтаар нэгтгэж, баримтжуулсан болно.

Аудитын явцад илрүүлсэн залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг В501 маягтаар нэгтгэж, баримтжуулсан бөгөөд байгууллагын удирдлага болон холбогдох албан тушаалтнуудад танилцуулж, баталгаажуулсан.

Дээрх залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг дараах байдлаар ангилав.

Залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг ангилсан байдал

(Сая төгрөгөөр)

№	Шийдэл	Тоо	Дүн	Тайлбар
1	Зөвлөмж өгсөн	1	0.80	
2	Төлбөрийн акт тогтоосон	1	0.10	
3	Албан шаардлага өгсөн	0	0.00	
4	Сахилгын шийтгэл ногдуулахаар шилжүүлсэн	0	0.00	
5	Хууль хяналтын байгууллагад асуудлыг шилжүүлсэн	0	0.00	
	Дүн	2	0.90	

2.9 Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

Байхгүй.

2.10 Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудитаар төсвийн шууд захирагч нь батлагдсан төсөв, түүний гүйцэтгэлийг зохих журмын дагуу зохион байгуулсан, үнэн зөв, тайлагнасан эсэхэд үнэлэлт өгөхийг зорьдог.

Баянцагаан сумын Ерөнхий боловсролын сургуулийн чиг үүргээ хэрэгжүүлэхтэй нь холбоотой хөтөлбөр, арга хэмжээнд зориулан 2018 онд 858602,9 мянган төгрөгийн төсөв батлагджээ. Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийн талаарх дэлгэрэнгүй мэдээллийг энэ тайлангийн 4.5-д дэлгэрэнгүй харуулав.

Төсвийн зардлын нийт гүйцэтгэл 857966,2 мянган төгрөг буюу 99,8 хувьтай байгаа нь цалин, НДШ 558,9 мянга, цэвэр бохир усны зардал 417,7 мянга, эд хогшил худалдан авах зардал 559,2 мянган төгрөгөөр хэмнэгдсэнтэй холбоотой байна.

Өөрийн орлогын төлөвлөгөө, гүйцэтгэл

Сургуулийн спорт заалны орлогоор 2018 онд 1000,0 мянган төгрөг оруулахаар төлөвлөсөн боловч гүйцэтгэлээр 601,2 мянган төгрөг оруулж, төлөвлөгөө 398,8 мянган төгрөгөөр тасарчээ.

2.11 Шилэн дансны мэдээлэл

Баянцагаан сумын Ерөнхий боловсролын сургууль Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг өөрийн цахим хуудсаар дамжуулан тухай бүр ил тод мэдээлж байх үүрэгтэй.

Тус байгууллагын Шилэн дансны хуулиар хүлээсэн үүргийн биелэлтийг төлөвлөсөн хэмжээнд хянаж, баримтжуулсан болно.

2.12 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга

Өмнөх санхүүгийн тайлангийн аудитаар итгэл үзүүлсэн байна.

2.13 Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Баянцагаан сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

Баянцагаан сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2018 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн болон бусад илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүдээ холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг байдлын хувьд алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

Аудитын гэрчилгээг энэ тайлангийн 1 дүгээр хэсэгт үзүүлэв.

3 МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДАЛ

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга АДБОУС болон аудитын дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь Баянцагаан сумын Ерөнхий боловсролын сургуулийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

2.8.1 ЗӨВЛӨМЖ ӨГӨХӨӨС БУСАД ХЭЛБЭРЭЭР ШИЙДВЭРЛЭСЭН АЛДАА, ЗӨРЧИЛТЭЙ АСУУДАЛ

Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчилтэй асуудлаас зөвлөмж өгөх асуудлыг Менежментийн захидалд оруулж, бусад хэлбэрээр шийдсэн алдаа, зөрчилтэй асуудлын дэлгэрэнгүйг дараах заалтад хураангуйлан тэмдэглэв. Үүнд:

2.8.1.1 Зардлын данстай холбоотой асуудал

Батлагдсан орон тоо 61 бөгөөд 12 сард 59 орон тоотой ажилласан байна. Цалингийн цэстийг давтан тооцоолж, цалингийн зардал, ажил олгогчоос төлөх НДШ-ийн зардалтай тулган шалгахад зөрүү гараагүй болно. Байгууллагын даргын шийдвэрийг бүрэн хэрэгжүүлээгүйгээс багш Ц.Галбадрахад 125691 төгрөгийн цалин илүү олгосон байна.

Энэ нь иж бүрэн байх гэсэн батламж мэдэгдэлтэй нийцэхгүйгээс гадна Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.4 дэх заалт, тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн: Төлбөрийн акт тогтоох

3.1 Балансын данстай холбоотой асуудал

3.1.1 Илрүүлэлт:

Оны эхэнд авлага, өглөггүй байсан бөгөөд оны эцэст ХХОАТ-т 12692 төгрөгийн өглөгтэй гарсан нь аудитаар нотлогдов. Тайлант хугацаанд 2 ажилтанд 800.0 мянган төгрөгийн цалингийн урьдчилгаа олгохдоо авлагаар бүртгэлгүй, өглөгийн дансаар бичилт хийжээ.

Энэ нь толилуулга ба тодруулга гэсэн батламж мэдэгдэлтэй нийцэхгүйгээс гадна Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.4 дэх заалт, Сангийн сайдын 2006 оны 388 тушаалаар батлагдсан төсөвт байгууллагад мөрдөх НББ-ийн дансны заавар тус тус зөрчсөн байна.

Мөн "Дэлхийн Зөн" ОУБ-тай сургуулийн захирал 2017.11.08-ны өдөр 82,0 сая төгрөгийн өртөг бүхий ариун цэврийн байгууламжийн бэлэглэлийн гэрээ байгуулж, 2017 онд төсвийн хөрөнгөөс 12,5 сая төгрөг шилжүүлж, 82,0 сая төгрөгийн хөрөнгийг 2017 онд орлогоор бүртгэжээ. 2018 онд хоолны зардлыг төсөвт урсгал зардлаар тодотгуулж, үлдэгдэл төлбөрт 19,4 сая төгрөг шилжүүлсэн байна. Энэ нь эрх ба үүрэг гэсэн батламж мэдэгдэлтэй нийцэхгүйгээс гадна Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14.4 дэх заалтыг зөрчсөн байна.

3.1.2 Эрсдэл:

Санхүүгийн тайлан, тодруулгад тусгасан авлага, өр төлбөрийн үлдэгдлийг харилцагч байгууллагаар хүлээн зөвшөөрүүлж баталгаажуулаагүй байх

3.1.3 Өгсөн зөвлөмж:

1. Сангийн сайдын 2006 оны 388 тоот тушаалаар батлагдсан "Төсөвт байгууллагад мөрдөх НББ-ийн дансны заавар"-ыг мөрдөж, цалингийн урьдчилгааг авлагаар бүртгэх, өмнөх онд өглөгийг санхүүгийн тайланд тусгаагүй холбогдох ажилтнуудад хариуцлага тооцох

2. Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14.4 дэх заалтыг зөрчсөн холбогдох буруутай албан тушаалтанд хариуцлага тооцож ажиллах

3.1.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар: Хүлээн зөвшөөрч байна. Хэрэгжүүлж ажиллана.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2019 оны 04 дүгээр сарын 10-ны дотор албан бичгээр ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

4 АУДИТЛАГДСАН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

/Төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>48,776,425.61</u>	<u>49,370,715.61</u>
35	БАРАА МАТЕРИАЛ	48,776,425.61	49,370,715.61
351	Түүхий эд материал	8,887,502.00	9,752,392.00
35110	Тусгай зориулалттай материал	8,887,502.00	9,752,392.00
354	Хангамжийн материал	38,758,923.61	38,488,323.61
35420	Аж ахуйн материал	17,051,726.00	17,051,726.00
35440	Түлш, шатах тослох материал	270,600.00	00.00
35470	Бусад хангамжийн материал	21,436,597.61	21,436,597.61
35600	Мал амьтад	1,130,000.00	1,130,000.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>1,033,033,733.48</u>	<u>1,542,275,979.41</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	1,033,033,733.48	1,542,275,979.41
392	Биет хөрөнгө	1,033,033,733.48	1,509,347,979.41
39201	Барилга, байгууламж, орон сууц	1,469,313,348.00	1,367,047,192.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	-610,913,906.46	-8,199,999.96
39203	Авто-тээврийн хэрэгсэл	1,200,000.00	1,200,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-1,200,000.00	-1,200,000.00
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	221,537,444.86	229,499,294.86
39206	Хуримтлагдсан элэгдэл	-119,329,476.99	-144,437,254.79
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	96,321,244.01	84,742,777.15
39208	Хуримтлагдсан элэгдэл	-62,016,371.72	-57,820,534.96
39214	Бусад үндсэн хөрөнгө	8,786,000.00	19,501,749.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	-1,601,830.67	-12,397,926.34
39217	Ном	30,937,282.45	31,412,682.45
393	Биет бус хөрөнгө	00.00	32,928,000.00
39301	Програм хангамж	1,180,000.00	1,180,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-1,180,000.00	-1,180,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	00.00	32,928,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>1,081,810,159.09</u>	<u>1,591,646,695.02</u>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	00.00	12,692.00
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	00.00	12,692.00
413	Өглөг	00.00	12,692.00
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	00.00	12,692.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>1,081,810,159.09</u>	<u>1,591,634,003.02</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	1,081,810,159.09	1,591,634,003.02
511	Засгийн газрын оруулсан капитал	380,614,036.70	413,542,036.70
51101	Өмч: - төрийн	380,614,036.70	413,542,036.70
512	Хуримтлагдсан үр дүн	-77,410,797.31	-158,669,315.98
51210	Өмнөх үеийн үр дүн	-77,410,797.31	-77,410,797.31
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	-81,258,518.67
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	778,606,919.70	1,336,761,282.30
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>1,081,810,159.09</u>	<u>1,591,646,695.02</u>

Баянцагаан сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

СТ-2А

САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН

/Төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	1,028,526,477.70	881,771,791.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	4,080,797.00	2,953,200.00
120	Нийтлэг татварын бус орлого	4,080,797.00	2,953,200.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	4,080,797.00	2,953,200.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	950,440.00	601,200.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	3,130,357.00	2,352,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	167,106,280.70	20,215,691.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	857,339,400.00	858,602,900.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	7,047,100.00	4,487,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	7,047,100.00	4,487,000.00
1330	Төсвийн захирагчдаас	139,117,910.70	00.00
133003	Хөрөнгийн	139,117,910.70	00.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	20,941,270.00	15,728,691.00
134001	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	20,941,270.00	15,728,691.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	947,085,003.71	958,690,608.39
21	УРСГАЛ ЗАРДАЛ	947,085,003.71	958,690,608.39
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	803,091,763.71	888,155,408.39
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	526,875,774.00	543,349,946.00
210101	Үндсэн цалин	450,931,738.00	431,327,849.00
210102	Нэмэгдэл	40,208,678.00	76,804,497.00
210104	Урамшуулал	21,772,344.00	35,217,600.00
210105	Гэрээт ажлын хөлс	13,963,014.00	00.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	67,147,079.00	65,573,277.00
210201	Тэтгэврийн даатгал	42,731,326.00	44,899,976.00
210202	Тэтгэмжийн даатгал	5,868,452.00	4,633,383.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	5,012,286.00	4,331,874.00
210204	Ажилгүйдлийн даатгал	1,242,671.00	1,014,598.00
210205	Эрүүл мэндийн даатгал	12,292,344.00	10,693,446.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	48,040,212.00	117,209,200.00
210301	Гэрэл, цахилгаан	4,994,162.00	5,185,009.00
210302	Түлш, халаалт	42,512,350.00	111,683,895.00
210303	Цэвэр, бохир ус	533,700.00	340,296.00
2104	Хангамж, бараа материалын зардал	8,888,400.00	6,231,790.00
210401	Бичиг хэрэг	1,731,000.00	1,102,400.00
210402	Тээвэр, шатахуун	4,250,700.00	3,166,890.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	169,900.00	60,000.00
210404	Ном, хэвлэл	301,300.00	349,800.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,435,500.00	1,552,700.00
2105	Нормативт зардал	48,056,635.00	40,609,510.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	531,400.00	373,200.00
210502	Хоол, хүнс	46,600,135.00	40,076,310.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	925,100.00	160,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	10,803,400.00	25,253,000.00
210604	Урсгал засвар	10,803,400.00	25,253,000.00
2107	Томилолт, зочны зардал	1,006,000.00	465,000.00
210702	Дотоод албан томилолт	1,006,000.00	465,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	17,435,100.00	1,913,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	17,435,100.00	1,913,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	74,839,163.71	87,550,685.39

Баянцагаан сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

210901	Бараа үйлчилгээний бусад зардал	4,783,020.00	3,650,730.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	300,000.00	3,172,140.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	69,756,143.71	80,727,815.39
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	143,993,240.00	70,535,200.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	143,920,570.00	69,297,291.00
213202	Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж	20,941,270.00	15,728,691.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	26,656,800.00	28,004,400.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	26,014,300.00	00.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	49,004,800.00	24,931,200.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	21,303,400.00	633,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	72,670.00	1,237,909.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	72,670.00	1,237,909.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	81,441,473.99	-76,918,817.39
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	00.00	4,339,701.28
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	00.00	2,363,957.68
225007	Хөрөнгийн дахин үнэлгээний зардал	00.00	1,975,743.60
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	00.00	-4,339,701.28
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	81,441,473.99	-81,258,518.67

СТ-2А

МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

/Төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	886,278,210.00	879,419,791.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	950,440.00	601,200.00
120	Нийтлэг татварын бус орлого	950,440.00	601,200.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	950,440.00	601,200.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	950,440.00	601,200.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	885,327,770.00	878,818,591.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	857,339,400.00	858,602,900.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	7,047,100.00	4,487,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	7,047,100.00	4,487,000.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	20,941,270.00	15,728,691.00
134001	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	20,941,270.00	15,728,691.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	886,278,210.00	879,419,791.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	886,278,210.00	879,419,791.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	741,899,170.00	808,884,591.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	545,604,639.00	543,337,254.00
210101	Үндсэн цалин	422,583,959.00	431,315,157.00
210102	Нэмэгдэл	63,723,196.00	76,804,497.00
210104	Урамшуулал	24,091,553.00	35,217,600.00
210105	Гэрээт ажлын хөлс	35,205,931.00	00.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	64,600,014.00	65,573,277.00
210201	Тэтгэврийн даатгал	51,623,080.00	43,958,197.00
210202	Тэтгэмжийн даатгал	3,330,630.00	5,575,162.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,817,350.00	4,722,675.00
210204	Ажилгүйдлийн даатгал	724,612.00	1,239,993.00

Баянцагаан сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

210205	Эрүүл мэндийн даатгал	6,104,342.00	10,077,250.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	31,495,362.00	116,938,600.00
210301	Гэрэл, цахилгаан	4,994,162.00	5,185,009.00
210302	Түлш, халаалт	25,967,500.00	111,413,295.00
210303	Цэвэр, бохир ус	533,700.00	340,296.00
2104	Хангамж, бараа материалын зардал	9,794,800.00	6,707,190.00
210401	Бичиг хэрэг	1,261,500.00	1,102,400.00
210402	Тээвэр, шатахуун	4,250,700.00	3,166,890.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	169,900.00	60,000.00
210404	Ном, хэвлэл	1,677,200.00	825,200.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,435,500.00	1,552,700.00
2105	Нормативт зардал	54,136,635.00	41,474,400.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	531,400.00	373,200.00
210502	Хоол, хүнс	46,600,135.00	40,076,310.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	7,005,100.00	1,024,890.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	10,803,400.00	25,253,000.00
210604	Урсгал засвар	10,803,400.00	25,253,000.00
2107	Томилолт, зочны зардал	1,006,000.00	465,000.00
210702	Дотоод албан томилолт	1,006,000.00	465,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	17,435,100.00	1,913,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	17,435,100.00	1,913,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	7,023,220.00	7,222,870.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	6,723,220.00	3,650,730.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	300,000.00	3,572,140.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	144,379,040.00	70,535,200.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	144,306,370.00	69,297,291.00
213202	Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж	20,941,270.00	15,728,691.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	26,656,800.00	28,004,400.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	26,014,300.00	00.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	49,004,800.00	24,931,200.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	21,689,200.00	633,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	72,670.00	1,237,909.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	72,670.00	1,237,909.00

Баянцагаан сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

СТ-4А

ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	/ төгрөгөөр /
				Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
2017 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	380,614,036.70	778,606,919.70	-77,410,797.31	1,081,810,159.09
2017 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	380,614,036.70	778,606,919.70	-77,410,797.31	1,081,810,159.09
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	380,614,036.70	778,606,919.70	-77,410,797.31	1,081,810,159.09
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	00.00	558,154,362.60	00.00	558,154,362.60
Тайлант үеийн үр дүн	32,928,000.00	00.00	-81,258,518.67	-48,330,518.67
2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	413,542,036.70	1,336,761,282.30	-158,669,315.98	1,591,634,003.02

ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Өмнөх оны		Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл				
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	840,289,800.00	858,217,170.00	859,602,900.00	857,966,191.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	840,289,800.00	858,217,170.00	859,602,900.00	857,966,191.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	736,217,700.00	734,852,070.00	806,007,000.00	804,397,591.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	551,765,200.00	545,604,639.00	542,661,100.00	542,359,254.00
210101	Үндсэн цалин	411,808,500.00	422,583,959.00	431,616,500.00	431,315,157.00
210102	Нэмэгдэл	75,827,000.00	63,723,196.00	75,827,000.00	75,826,497.00
210104	Урамшуулал	35,217,600.00	24,091,553.00	35,217,600.00	35,217,600.00
210105	Гэрээт ажлын хөлс	28,912,100.00	35,205,931.00	00.00	00.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	60,693,900.00	64,600,014.00	63,783,900.00	63,526,277.00
210201	Тэтгэврийн даатгал	38,623,500.00	51,623,080.00	43,579,900.00	43,348,197.00
210202	Тэтгэмжийн даатгал	4,414,100.00	3,330,630.00	4,374,200.00	4,368,162.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	5,517,600.00	2,817,350.00	4,221,300.00	4,661,675.00
210204	Ажилгүйдлийн даатгал	1,103,500.00	724,612.00	1,055,300.00	1,223,993.00
210205	Эрүүл мэндийн даатгал	11,035,200.00	6,104,342.00	10,553,200.00	9,924,250.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	36,754,400.00	31,495,362.00	117,295,400.00	116,938,600.00
210301	Гэрэл, цахилгаан	4,781,700.00	4,994,162.00	5,185,100.00	5,185,009.00
210302	Түлш, халаалт	31,238,700.00	25,967,500.00	111,352,300.00	111,413,295.00
210303	Цэвэр, бохир ус	734,000.00	533,700.00	758,000.00	340,296.00
2104	Хангамж, бараа	11,034,000.00	9,794,800.00	6,698,800.00	6,707,190.00

Баянцагаан сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

	материалын зардал				
210401	Бичиг хэрэг	1,261,900.00	1,261,500.00	1,092,400.00	1,102,400.00
210402	Тээвэр, шатахуун	3,168,000.00	4,250,700.00	3,168,000.00	3,166,890.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,544,500.00	169,900.00	60,000.00	60,000.00
210404	Ном, хэвлэл	1,623,200.00	1,677,200.00	825,700.00	825,200.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,436,400.00	2,435,500.00	1,552,700.00	1,552,700.00
2105	Нормативт зардал	63,854,700.00	54,136,635.00	41,502,900.00	41,474,400.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	497,200.00	531,400.00	400,300.00	373,200.00
210502	Хоол, хүнс	59,132,000.00	46,600,135.00	40,029,200.00	40,076,310.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	4,225,500.00	7,005,100.00	1,073,400.00	1,024,890.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	2,425,000.00	10,803,400.00	25,852,200.00	25,253,000.00
210604	Урсгал засвар	2,425,000.00	10,803,400.00	25,852,200.00	25,253,000.00
2107	Томилолт, зочны зардал	1,010,800.00	1,006,000.00	514,200.00	465,000.00
210702	Дотоод албан томилолт	1,010,800.00	1,006,000.00	514,200.00	465,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	918,600.00	10,388,000.00	467,300.00	451,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	918,600.00	10,388,000.00	467,300.00	451,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	7,761,100.00	6,723,220.00	7,231,200.00	7,222,870.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	7,761,100.00	6,723,220.00	3,654,500.00	3,650,730.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	00.00	00.00	3,576,700.00	3,572,140.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	104072100.00	123365100.00	53595900.00	53568600.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	104,072,100.00	123,365,100.00	53,595,900.00	53,568,600.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	31,722,000.00	26,656,800.00	28,030,500.00	28,004,400.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	26,014,300.00	26,014,300.00	00.00	00.00
213208	Хөдөө орон нутаг тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	45,678,800.00	49,004,800.00	24,931,200.00	24,931,200.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	657,000.00	21,689,200.00	634,200.00	633,000.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	840,289,800.00	858,217,170.00	859,602,900.00	857,966,191.00
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	839,789,800.00	857,266,730.00	858,602,900.00	857,966,191.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	839,789,800.00	857,266,730.00	858,602,900.00	857,966,191.00
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	500,000.00	950,440.00	1,000,000.00	601,200.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос	500,000.00	950,440.00	1,000,000.00	601,200.00

Баянцагаан сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

	санхүүжих				
3, 62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	72.00	71.00	68.00	68.00
620001	Удирдах ажилтан	03.00	03.00	03.00	03.00
620002	Гүйцэтгэх ажилтан	44.00	44.00	44.00	44.00
620003	Үйлчлэх ажилтан	16.00	15.00	21.00	21.00
620004	Гэрээт ажилтан	09.00	09.00	00.00	00.00